



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2011 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 132

Улаанбаатар хот

Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнэ тарифын өөрчлөлтийг харгалзан төсвийн норм, нормативыг шинэчлэх зорилгоор ТУШААХ нь:

Нэг. Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнэ тарифын өөрчлөлттэй уялдуулан улс төрийн болон төрийн захиргааны албан хаагчийн албан томилолтын зам хоног, байрны зардлын хэмжээг суманд 18,000 төгрөг, аймгийн төвд 29,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 35,500 төгрөгөөр, төрийн тусгай болон үйлчилгээний албан хаагчийн хувьд зам хоногийн зардлыг суманд 12,000 төгрөг, аймгийн төвд 14,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод 16,000 төгрөгөөр тус тус тогтоосугай.

Хоёр. Төрийн тусгай болон үйлчилгээний албан хаагчийн хувьд байрны зардлыг зочид буудалд байрласан баримтыг үндэслэн зам хоног, байрны зардлын нийт дун нь улс төрийн болон төрийн захиргааны албан хаагчийн албан томилолтын зам хоног, байрны зардлын нийт хэмжээнээс хэтрэхгүй байхаар тооцож олгохыг төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, төсвөөс санхүүждэг байгууллагуудын эрх баригч нарт зөвшөөрсүгэй.

Гурав. Энэхүү тушаалыг 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр тогтоосугай.

Дөрөв. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Сангийн сайдын 2006 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 64 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

С.БАЯРЦОГТ

САНГИЙН ЯАМНЫ АРХИВ
ХҮУЛБАР ҮНЭН

Бүртгэлийн № 05

Төрийн захиргааны удирдлагын газаршидэгээ

Архивын эрхлэгч
Нийт хуудас 2011 онон сарын 14 өдөр

08 0152